

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН
05 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 05 дугаар сарын 29

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.06.28	2019.06.21	A/619	Паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын гадна болон дотор инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулагдаж, дүүргийн хангагч байгууллагуудтай зөвшилцөн магадлалаар хянагдан баталгаажсан. Зураг төслийн төсвийг эцэслэн боловсруулан, төсвийн экспертэд хянуулан, өгсөн заавар зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлтийг оруулан батлуулж, нэгдсэн дүгнэлт гаргуулахаар бэлтгэж байна.
2	2019.10.11	2019.10.09	A/1054	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар нийт 21 бичиг ирснээс хариутай бичиг 7, хариугүй бичиг 14, хариутай болон хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас яам, нийслэл, аж ахуй нэгж, байгууллагуудад 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар нийт 19 албан бичиг явуулсан ба явсан бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна.
3	2020.01.28	2020.01.27	A/108	1.6 дугаар заалтын дагуу Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, өглөө бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж, 7 хоног бүрийн Баасан гарагт их цэвэрлэгээг хийж байна. Мөн ЭМЯ болон дүүргийн ЭМТ-өөс өгч байгаа зөвлөмж, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан, baganuur-itp.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна. Захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гаригт zendmaal@gmail.com цахим хаягт илгээн тайлагнаж байна.
4	2020.02.07	2020.02.07	A/168	3 дугаар заалтын дагуу 05 дугаар сарын 29-ний байдлаар Их цэвэрлэгээ – 90 минут, дүүргээс зохион байгуулсан Ногоон бүсийн их цэвэрлэгээнд хамт олноороо идэвхитэй оролцож, тайланг хугацаанд нь хүргүүлсэн. Захирамжийн биелэлтийг 14 хоног тутам НЗДТГ-ын ХШ, ҮХ-т тайлагнан ажиллаж байна.
5	2020.02.14	2020.02.13	A/191	Захирамжийн дагуу НОК-ын орлогч даргын баталсан "Шинэ төрлийн коронавирус /COVID-19/-ын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч, эргүүлээр ажиллах хуваарь"-ийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн баталсан хуваарийн дагуу явган эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг боловсруулан нэгтгэж, орой бүр 21:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабт, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ubhealth2020@gmail.com цахим хаягаар, дүүргийн Онцгой комисст 7021101 утсаар тайлагнаж,

				<p>эргүүлээр ажилласан тоон мэдээг 7 хоногоор нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоног бүрийн баасан гарагт battsoojbcity@gmail.com цахим хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2 албан хаагч долоо хоног бүрийн бямба гарагт Нийслэлээс орох, гарах тээврийн хэрэгслийн бүртгэлээр Гүнтийн давааны постонд 24 цагаар ажиллаж байна.</p>
--	--	--	--	---

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Lazurit

Б.НОМИНЗУЛ